



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

“Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 36,990,909 (гучин зургаан сая есөн зуун ерөн мянга есөн зуун ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ (Л.Ариунтуяа)-т зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ (Л.Ариунтуяа)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА  М. БАЯРАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2022 оны 02 сарын 19 -ны өдрийн
 А/51 тушаалын хавсралт



СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ
 ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Автомашинны марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Эвдрэл гэмтэл	
1	Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ	Хьюндай соната-6 09-96 УНЕ	2008/2009	Суудал БНСУ Хар	КМНЕТН1AD 9A632117	224926	29,900,000	Хөдөлгүүр, рулийн аппарат эвдэрсэн, урд хойд тэнхлэг амортизатор тос хаясан, редуктор тормозны механизм ажиллахгүй, аккумулятор суусан, манай нөхцөлд солих боломжгүй, кольцо элэгдсэн зэргээс битүүмж алдагдаж асалтгүй болсон, хурдны хайрцаг эвдрэлтэй, кабины салхины шил хагарсан, Техникийн комиссын дүгнэлтээр тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага хангахгүй, бусад эд ангиудын ашиглалтын хугацаа дууссан	
2		Истана 63-52 УНЛ	2001/2008	Суудал БНСУ Цагаан	KPDGBDH81 1P137952	234315	7,090,909		
нийт								36,990,909	